

Билэг утга төгөлдөр судар
 “Бурханы айлдвар” хэмээх бүлэг

The World of the Lotus Sutra

Бодисадва: бусад бодисадвагийн хамтаар ингэж асуув. «Төөрч, будилахгүйгээр бурханы гэгээрэлд хүрэхийн тулд ямар сургаалийг, хэрхэн, яаж хэрэгжүүлэх вэ»

Шагжамуни будда: «“Хязгааргүй утгын тухай сургааль” нь дээр үгүй гэгээрэлд хүргэнэ. Энэ сургааль нь “Орчлонгийн бүх зүйлийн үндэс нь тэгш чанартай бөгөөд нэгэн том эв нэгдлийг бүтээдэг” гэдгийг илтэд мэдэгтүн. Гэвч хүмүүс туйлын үнэний сургаалийг мэдэхгүйн улмаас юу ч байсан ашигтай, ашиггүй хэмээн сэтгэж, муу сэтгэлийг үүсгээд, зовлонгийн зургаан орон (орчлонгийн 6 хүрд) -нд цувиран эргэж байдаг» хэмээв.

«Үүнийг илтэд мэдээд, хүмүүсийг өрөвдөн хайрлах сэтгэлийг үүсгэ. Улмаар хүмүүсийг аварьяа хэмээн сэтгэлээ шулуутга. Түүнчлэн юмс үзэгдлийн өнөөгийн төрх, байдлыг зөв таньж мэдэгтүн. Орчлонгийн юмс бүхэн төрж, оршин, өөрчлөгдөн, алга болдог (үүсэх, орших, ялгарах, устах) гэдгийг сайтар тунгаан ойлго. Тэгж чадвал орчлонгийн бүх зүйл үргэлж үүсэн, алга болдог бөгөөд тэрхүү хувьсал нь хором мөч төдий ч зогсолгүй үргэлжилдэг гэдгийг ойлгоно. Түүнчлэн хүмүүсийн ойлгох чадвар, зан ааш, хүсэл шунал түм буман янз гэдгийг ойлгоно. Хүмүүсийн ойлгох чадвар, зан ааш, хүсэл шунал түм буман янз болохоор тэдгээрт тааруулан айлдсаар сургааль маань хязгааргүй утгатай болдог. Гэвч тэрхүү хязгааргүй утгын сургааль нь нэг л сургаал (язгуурын төрх) -иас үүсдэг» хэмээн айлдав.

Бодисадва: дахин ингэж асуув. «Шагжамуни

багшаа та өдii хүртэл маш олон сургааль айдсан. Тэдгээр сургаалийг сонсоод гэгээрэлд ойлтсон хүмүүн ч бий. Дөнгөж сая айлдсан “Хязгааргүй утгын тухай сургааль” өдий хүртэл айлдаж ирсэн сургаалиудаас тань юугаараа ялгаатай юм бэ»

Шагжамуни будда: «Би бээр гэгээрлийг олсныхоо дараа энэ орчлонг хараад, үнэний сургаалийг шууд айлдах нь зүй бус хэмээн сэтгэв. Улмаар сургаалийг хүн тус бүрт тохируулан айлдаж, авран, замчилж ирсэн. Тиймээс өдийг хүртэлх 40 жилийн хугацаанд туулийн үнэний сургаалийг айлдах боломж байсангүй. Бурхад айлдсан сургааль бүхэн үнэндээ бол нэг юм. Түүнийг гагцхүү бурхад л ойлгоно. Хэрвээ гэгээрэлд хүрье гэвэл хязгааргүй утгын тухай сургаальд суралцаж, хэрэгжүүлэхийн тулд хичээгтүн» хэмээн хариулав.

Тэгтэл хамаг амьтад машид баясан Шагжамуни будда болон Бодисадва нарыг магтан дуулав. Бас бодисадва нар “Хязгааргүй утгын тухай сургааль”-ийн утгыг ойлгосон тул тарний (мууг хорьж, сайныг хөгжөөх) хүчийг олов. Номын тавцнаа хуран цугласан бусад хүмүүс элдвийг танин мэдээд (дээр үгүй гэгээрлийг олохын тулд дияанд шамдъяа) сэтгэл шулуудав.



Special Topics

Хавай нийгэмлэгийн шинэ тэргүүний танилцуулга

Өнгөрөгч оны 12 дугаар сарын нэгнээс Хиронака Шигэаки гуай Хавай нийгэмлэгийн тэргүүнээр томилогдлоо. Хиронака тэргүүн нь “Такүрин” шашны сургууль “Охайо” их Сургуулийн магистерийн зэрэг хамгаалжээ. Тэрээр нутагтаа эргэж ирээд “Залуучуудын төв”, “Такүрин” шашны сургуулийн дэд даргаар ажиллаж байгаад Хавай нийгэмлэгийн тэргүүнээр томилогдож байна.

Мөн 2004 оны 12 дугаар сараас хойш 6 жилийн турш Хавай нийгэмлэгийн тэргүүнээр ажиллаж байсан Хосояма Юүсүкэ гуай Канагава мужийн Кавасаки

нийгэмлэгийн тэргүүнээр томилогдлоо. Хоёр тэргүүнийхээ цаашдын ажил үйлсэд амжилт хүсье.



Rev. Hosoyama

Rev. Hironaka

Аврах, аврагдахуйн мөн чанар

Рисшо Косей-Кайгийн ерөнхийлөгч
Нивано Ничико

“Аврал” гэж юу вэ?

Шинэ оны босго алхах энэ торгон мөчид сүсэг бишрэлийн үндэс хэмээн хэлж болох «Аврах, аврагдахуй»-н тухай эрэгцүүлж үзлээ.

Хүмүүс ихэвчлэн хүнд, хэцүү асуудалтай тулгархаараа бурхан, тэнгэрийг санадаг.

Энэ тухай сударт «Яаж эдгээр амьтан нугуудыг дээр үгүй номын замд оруулж, Ялж төгс нөгчсөн ариун хутагийг олох болтугай хэмээн би бээр ямагт сэтгэлдээ бясалгамай» (Түүнчлэн ирсэний насны хэмжээ хэмээх 16-р бүлэг) хэмээсэн байдаг.

Энэ нь «Ямар нэг аргаар хамаг амьтаныг бурханы замд хөтлөн оруулж, аль болох хурдан гэгээрлийг олуулаад, аз жаргалтай болгохын төлөө, би бээр үргэлж залбирч байдаг» гэсэн утгатай юм.

Өөрөөр хэлбэл бурхан багш биднийг аварьяа хэмээн үргэлж хүсэн залбирч байдаг юм.

Аврал эрсэн хүний хувьд өмнөө байгаа зовлон, бэрхшээлийг шийдвэрлэж чадвал амьдрах эрч хүчтэй болдог. Гэвч (хамаг амьтад аль болох хурдан гэгээрлийг олоосой) хэмээн хүсэх бурхан багшийн хувьд арай өөр утгатай болов уу.

Гишүүний тангарагт «Угийн авралын утгыг бурхан багшийн номд үзмүй» гэсэн нэг шад өгүүлбэр байдаг. Нэг үгээр хэлбэл «Аврах, аврагдахуйн» утгыг мэднэ гэдэг маань сүсэг бишрэлийн үндэс суурийг ойлгоно гэсэн утгатай юм.

Угийн авралын тухай өгүүлсэн гишүүний тангарагын энэхүү нэг мөр өгүүлбэр нь РКК-ын онцлогийг харуулаад зогсохгүй Цагаан Лянхуа Судрын үзэл санаа, билэг оюуныг тусган харуулсан байдаг.



Хүмүүс «Бурханы шашны угийн аврал»-ын тухай сонсохоороо ойлгоход амаргүй мэтээр төсөөлдөг ч үнэндээ бол хэн ч байсан ойлгохоор энгийн зүйл юм.

Өөнөөдрөөсөө, аль хэдийнээ хүртчихсэн байгаа аз жаргалыг анзаарч «Баярлалаа» хэмээн талархаж, өөрийг тань бүчиж, хүрээлсэн ачитнуудыг анзаарах нь л тэр чигтээ угийн аврал юм.

Сургаалиас суралцаж, хэрэгжүүлээд явах явцад өөрийн эрхгүй амнаас тань «Баярлууштай», «Бусдын ачаар» гэсэн үгийг хэлдэг болсон үед бид авралын зам дээр зогсож байдаг. Гэвч дараах өдөр нь сэтгэл ханамжгүй байдлаа илэрхийлж, гомдол тоочиж эхэлдэг нь хүний зан. Тиймээс сургаальд дахин дахин давтан суралцах дадлыг өөртөө бий болгох нь чухал юм.

Нэгэн хутагт «Сэтгэлийн язгуурыг бурхан хэмээвээс үүнийг ухаарахыг гэгээрэл хэмээмүй. Түүнд төрөөлдөгсөдийг хамаг амьтад хэмээмүй» гэж хэлсэн байдаг шиг гэгээрэл, төөрөгдөл хоёр нь нэг зүйлийн ар, өвөр шиг зүйл юм. Өөрөөр хэлбэл бурхан,

хийгээд хамаг амьтан бүхэн нь нэг зүйлийн ар, өвөр бөгөөд бие, биедээ шүтэн барилдсан нэг бие гэдгийг ухаарахаар зорьсон тэр цагт аврах, аврагдахуй оршиж байдаг.

Үүнийг анзаарч чадвал «Энийг ч авахсан, тэрийг ч авахсан» гэх гуйлгачин амьдралаа «Баярламаар, бусдын ачаар амьдарч явна» хэмээн бүх зүйлд, талархсан баяр баясгалантай амьдрал болгон өөрчилж чадна.

Шагжамуни будда «Энэ орчлонгийн юмс санасны дагуу болдоггүй жамтай. Гагцхүү өөрөө өөрийгөө хянан захирч болно» хэмээн сургасан. Тиймээс өөрийгөө өөрчилж болох ч бусдыг сансныхаа зоргоор өөрчилж чадахгүй. Ерөөс бурханы шашин гэдэг маань «Сургаалийг түшсэн өөртөө найдах» тухай сургасан байдаг.

Аз жаргал, аврал нь хаа нэгтээ хол газар байдаг юм биш. Аль хэдийнэ хүртчихсэн байгаа аз жаргал, өөрийг чинь бүчиж хүрээлсэн ачитнуудыг анзаарч болох өдөр бүрийн амьдрал дунд чинь байгаа. Хүн бүрийн сэтгэл дотор байгаа.

“Косэй” 2011 оны 1 сарын дугаараас



Хязгааргүй их баяр баяслыг хүртсэн ариун ордны мөргөл !

Бразилийн нийгэмлэг
Милян Апарэшида Гомэс Петратори



※Энэхүү илтгэл нь 11 сарын 7-нд Бразилийн нийгэмлэг дээр болсон “Үүсгэн Байгуулагчийн Мэндэлсэний ойн баяр” дээр тавигдсан юм.

Сайн байцгаана уу? Ариун ордонд мөргөлөөр ирсэн явдалд талархсанаа илэрхийлээд яриагаа эхэлье.

Урт хугацааны аянд ядарч, цагийн зөрүүнээс болсон уу ханиад хүрчихлээ. Гэвч олон сайхан туршлага хуримтлуулаад сэтгэл их хөдөллөө. Үнэндээ би Ариун ордон руу мөргөлөөр ирнэ гэж төлөвлөгүй байсан. Гэвч Токиод ирсэн дариудаа “Бурхан багш намайг энэ хүртэл дагуулж иржээ” гэж бодсон.

Ариун ордонд орж, бурхан багшид мөргөх агшинд бурхан багш биднийг баясан угтаж байгаа мэт санагдсан. Би шашин бүрийг хүндэтгэн үздэг. Түүнчлэн шашин бүрийн үндэс, Суурь адилхан гэдэгт итгэдэг. Ариун ордоныг бүтээхдээ баруун, зүүн европын соёлоос хамтатган авч оруулсан тухай сонсоод сэтгэл их хөдөлсөн.

Үүсгэн байгуулагчийн сургаальд суралцах хувь надад оногдсон.

Түүний сургааль дэлхийд энх тайвныг бүтээж чадна гэж би бодсон. Ариун ордны мөргөл нь надад ингэтлээ нөлөөлнө чинээ төсөөлөөгүй ээ.

Би «Хүн оюун ухааны өндөр хөгжилтэй байх нь чухал» гэж боддог байв. Гэвч 13 настайгаасаа эхлэн хүний амьдралд сүсэг бишрэл, шашны удирдагч нар хэрэггүй гэж бодох болсон.

Угаас хүн хийгээд оршиж буй бүх зүйлд тэнгэр, сахиус байдаг гэж итгэдэг байлаа. Тэрхүү тэнгэр, сахиус миний хувьд шашин бас багш болдог байсан. Ингэж итгэх нь надад амьдрах эрч хүч болдог байлаа.

Би шашны олон урсгалтай учирч сургаалиас нь суралцаж байсан ч сүсэгтэн больёо гэж бодож байсангүй. Тэр дундаас бурханы шашины сургааль утга төгөлдөр, зөв зүйтэй мэт бодогддог байсан ч ойлгоход нарийн төвөгтэй санагддаг байв.

Нэг удаа Бразил дахь сургааль түгээх “Можиг” төвийн семинарт оролцож, бурханы сургаалийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болдогийг мэдсэнээр Косей Кайг сонирхож эхэлсэн.

Гэвч сэтгэл дотроо өөрийгөө РКК-ын гишүүн гэж боддоггүй байлаа. Тухайн үед би Үүсгэн байгуулагчийг Косей Кайгийн гол хүн гэдгээс өөрөөр боддоггүй байлаа. Тийм бодлоос өөрийг өвөрлөөгүй явсан би бээр ариун ордны мөргөлд оролцоод олон гайхалтай туршлага хуримтлууллаа.

Ариун ордны бясалгалын өрөөнд бясалгал хийж байх үед зүрхэн тарнийг баргил дуугаар урин унших эрэгтэйн дуу хоолой яг л дэргэдээс минь гарч байх шиг сонсогдсон. Тэр дуу хоолой үүсгэн байгуулагчийн дуу хоолой байсныг “Үүсгэн байгуулагчийн дурсгалын музей”-тэй танилцах үедээ мэдсэн юм.

Үүсгэн байгуулагчийн дурсгалын музейд бясалгалын үеэр сонссон дуу хоолойг дахин сонсох үед би нулимсаа барьж тэвчээгүй юм. Бүх зүйлсийн тохироо бүрдсэн байсан болохоор сэтгэл минь уярч уйлсан гэж бодохгүй байна. Үүсгэн байгуулагчийн дуу хоолойг сонссон тэр мөчөөс эхлэн Үүсгэн байгуулагч миний амьдралын нэг хэсэг болсон болохоор уйлсан



Шанзай хэвлэлийн хамт олон та бүхний сүсэг бишрэлийн арвин их турлагаасаа өгүүлсэн илтгэлийг хүлээн авсаар байгаа. Шанзайгаар дамжуулан дэлхийн хүмүүст өөрийн туршлагаас хуваалцахыг хүсвэл дараах электрон хаягаар холбоо барина уу? shiho.matsuoka@kosei-kai.or.jp

shanzai

I determined that I would make it my mission to learn the Founder's teachings, and I believed that his teachings could bring peace to the world.

гэж бодож байна. Түүнээс хойш РКК-ын билэг тэмдэг болсон ариун ордныг харах тоолондоо түүний сүр жавхланд сэтгэл уярдаг болов. Одоо би жинхэнэ утгаараа РКК-ын гишүүн боллоо.

Ариун ордон үнэхээр сүр жавхлантай. Барилгын ур, хийц нь маш нарийн бөгөөд бурханы шашны сургаалийг илэрхийлсэн байсан болохоор сэтгэл их хөдөлсөн. Ариун ордон үнэхээр гайхалтай газар. Өдөр бүр очиж судар хурсан ч шинэлэг сэтгэгдэл төрүүлж байсан. Ариун ордон бол дахин дахин мөргөлөөр ирэх учиртай газрын нэг гэж бодож байна.

Яриа маань өндөрлөх дөхөж байгаа ч ариун ордны мөргөлд оролцоод өөрийнхөө хувиа хичээсэн үзлийг анзаарлаа. Ханиад хүрхээрээ хувиа хичээх үзэлд хэт баригддаг гэдгээ мэдлээ. Бас өөрийгөө болон бусдыг уучилах нь, их чухал гэдгийг ойлголоо.

Түүнчлэн “Нэг Хөлгөний баяр”-ын фестивалд

оролцож чадсан маань их чухал үйл явдал болсон. Маш гүн утгатай, хөл хөөр ихтэй баяр байсан. Маш олон хүний хайрыг мэдэрч хамтдаа бүхэл бүтэн 45 минут инээмсэглэн бүжсэн. Бүжиг өндөрлөх үед ядарсан гэхээсээ илүү харин ч их эхерги авсан мэт санагдсан.

Японы соёлын нэг хэсгийг харж чадсандаа их баяртай байна. Миний харсан Япон орон уламжлалт соёлоо орчин үеийн техник технологтой чадварлаг хослуулсан байсан.

Өмнө би хэл соёлын хувьд ялгаатай олон хүмүүстэй уулзаж, учирч байсан ч энэ удаагийнх шиг сэтгэлд таатай байсан нь анх удаа юм.

Бурхан багш, Үүсгэн байгуулагч, Ерөнхийлөгч бас биднийг ая тухтай хүлээн авсан хүмүүс, мөргөлд хамт оролцсон хүмүүс, эцэст нь илтгэлийг минь чих тавин сонссон та бүхэнд талархсанаа илэрхийлье. Их баярлалаа.



” Номын хүрдэн” өргөөний гаднах цэцэрлэгт хүрээлэнд

Улсын эрдэнэ

Сар шинийн мэнд хүргье. Шинэ оны босго алхах энэ торгон агшиныг тохиолдуулан та бүхнийг шинэ ондоо аз жаргалаар дүүрэн байхыг хүсэн залбирьяа.

Өнгөрөгч онд дотоод, гадаадад янз бүрийн асуудал өрнөлөө. Ямартаа ч ийнхүү сар шинийн баяраа угтаж чадсандаа талархаж, шинэ оноо шинэлэг сэтгэлтэйгээр угтацгаая.

Өнгөрсөн жил эцэг, эхийнхээ санааг нэлээдгүй чилээчихлээ. «Хичээе, хичээе гэж хэлсээр ганц ч болов өөртэй зүйл хийж чадсангүй» гэсэн бодлоо ардаа орхиж, «Шинэлэг сэтгэлээр урагш алхая» хэмээн сэтгэлээ тэгшитгээд шинэ оныхоо эхний алхамыг хийхээр зэхэж байгаа болов уу.

Япон улс нь байглын баялаггүй орон. Гагцхүү ард түмэн маань, улсын өв хөрөнгө, эрдэнэсийн сан юм.

Дэнгио хутагт «Алт эрдэнэс арвин байлаа ч улсын эрдэнэс үл болно. Алд газрыг гийгүүлэгч нь улсын эрдэнэс болой» гэж хэлсэн байдаг. Оногдсон ажилдаа үнэнч байж, тэр алба, тэр газарт байхгүй л бол болохгүй хүн байх нь «Алд газрыг гийгүүлэгч хүн» болой. Үгүй болчихвол орон зай нь үгүйлэгдэх, тийм нэг эрхэм дүр төрхөөрөө эргэн тойрныхоо хүмүүсийг зөв замд удирдан хөтөлж чадвал улс орон хөгжих нь гарцаагүй. Ийм хүн л улсын эрдэнэ билээ. Тиймээс оны эхэнд сэтгэлээ тэгшлэгтүн. Энэ л жинхэнэ сар шинийн утга учир билээ.

Үүсгэн Байгуулагчийн үг 5, 10-11х.

Information Jan. 2011

SHAN-ZAI-сэтгүүл нь та бүхний санал сэтгэгдэлийг хүлээж авсаар байгаа. “Сонирхсон сэдэв”, “Буддизмын талаар мэдмээр байгаа зүйл”, “Сэтгэл зовоосон асуудал” байгаа бол бидэнд хандаарай. Бид та бүхний саналыг талархан хүлээж авна. Харилцах хаягийг энэ хуудасны доод булангаас харна уу.

COLUMN

Сар шинийн босгон дээр Ерөнхийлөгч гишүүд бидэнд хандаж шинэ ондоо сэтгэлээ хэрхэн авч явах тухай айлдсан. Өнгөрсөн жил «Номын сайн анд» болохын тухайтад хичээгтүн хэмээн айлдсан. Нэг жил гэдэг үнэхээр хурдан юм. Хүмүүст «Номын сайн анд» болж чадсан болов уу. Яагаад ч юм сэтгэл дотроо өөрөөсөө ичнэ. Тэглээ гээд өөрийнхөө дутууг харж санаа алдан суугаад байж болохгүй. Шинэ оныг угтаж байгаа болохоор сэтгэлээ шинэчлэхгүй бол болохгүй.


Энэ жил Ерөнхийлөгч маань “Ерөнхийлөгчийн үүрэг”-ээ залгамжилж аваад 20 дахь жилтэйгээ золгож байна. Бас сургааль дэлгэрүүлэх ОУ-ын төв үүсч хөгжөөд тав дахь жилтэйгээ золголоо. Билэг дэмбрэлтэй олон утга агуулсан энэ онд бид сэтгэлээ хэрхэн төвшитгөж, амьдралаа хэрхэн залвал зохистой юм бол.

Ерөнхийлөгч «Өнөөдрөө чухалчилж амьдар» хэмээн сургалаа. Тиймээс эрхэм гишүүд, сүсэгтэн олон минь, өнгөрсөнд үл баригдаж, ирээдүйд сэтгэлээ чилээлгүй, одоо өөртөө байгаа хамаг хүчээ дайчилан өнөөдрөөрөө амьдарцгаая. Ингэж гэмээнэ энэ жил ч гэсэн сайхан жил болох нь эргэлзээгүй.

(Kotaro Suzuki)

Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганума Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэцгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр бүлээрээ шүтэх шашинь нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрай ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьдог юм.



SHAN-ZAI 2011 он 1сар (Vol.64)

[Эрхлэн гаргач] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв. Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, 166-8537 Japan, TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224, E-mail : shanzai@kosei-kai.or.jp
Ерөнхий редактор: Хагивара Туслах редактор: Ms. Etsuko NAKAMURA Ажилчид: Шихо-Мацүока, Юүкино-Күдо, Каори-Сайто, Маюүми-Это, Саюүри-Сүзүки, Эрико-Кано, Макино-Эми

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2011

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@buddhistcenter-rkina.org <http://www.buddhistcenter-rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.rkina.org/tampabay>

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@mail.rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rk-la.com>

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: tozuna48@yahoo.com

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Denver

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-5569
e-mail: rkksf@sbcglobal.net

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

851 N San Mateo Dr, San Mateo, CA 94401, U.S.A.

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami3370@hotmail.com

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

724 Main St. Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

4340 E Kentucky Ave #345 Glendale CO 80234, U.S.A.
Tel: 1-303-319-2765 Fax: 1-720-876-4534

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: hiromi_mat@yahoo.com <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilong

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic
of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, the Russian Federation
Tel & Fax: 7-4242-43-78-56

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 Fax: 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Sydney**Rissho Kosei-kai of Singapore****International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp http://www.ibrk.or.jp/

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 Fax: 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

"Suwisal" Bataganwila, Imaduwa, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 Fax: 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 Fax: 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Other Groups**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

114, Nanshi Si Road, Zenruzhen, Putuo-qu, Shanghai, China